

### I. Нийгмийн үзвэлэлт

Эрүүл мэндийн яамны мэдээгээр 2010 оны эхний улирлын байдлаар 1000 хvн амд ногдох торолт 6.1, нас баралт 1.6, хvн амын ердийн цэвэр осолт 4.5 байна.

Улсын хэмжээнд амьд торсон хvvxдийн тоо 2010 оны эхний улиралд 16875 болж, омнох оны мон veийнхээс 540 хvvxдээр буюу 3.3 хувь, амаржсан эх 16823 болж 545 эхээр буюу 3.3 хувиар тус тус нэмэгджээ.

Нэг хvртэлх насандаа 383 хvvxэд эндэж, омнох оны мон veийнхээс 48 хvvxдээр буюу 14.3 хувь, 1-5 хvртэлх насандаа эндсэн хvvxдийн тоо 101 болж 54 хvvxдээр нэмэгдэж, харин эхийн эндэгдэл 8 болж 4 эхээр буурсан байна.

Ажиллах хvчний судалгааны 2009 оны жилийн эцсийн дvнгээр нийт 131.6 мянган ажилгvй иргэд байгаа богоод тэдгээрээс 51.8 мянга буюу 39.3 хувь нь эмэгтэйчvвд байна. 2009 оны байдлаар ажилгvйдлийн тvвшин 11.6 хувь болов.

Аймаг, нийслэлийн хоѳолмор, халамжийн vйлчилгээний хэлтэс (ХХҮХ)-г бvртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгvй иргэдийн тоо 2010 оны 3 дугаар сарын эцэст 37.1 мянга болж, омнох оны мон veийнхээс 2355 хvн буюу 6.8 хувиар осчээ. Ажилгvйдлийн энэхvв осолтонд бvртгэлтэй ажилгvй иргэдийн тоо омнох оныхоос Тов (445 хvн), Ховд (448 хvн), Увс (465 хvн), Баянхонгор (557 хvн), Дархан-Уул (592 хvн), Завхан (704 хvн) аймагт нэмэгдсэн нь голлон нолоолжээ...

Нийгмийн даатгалд 2010 оны эхний улиралд 397.5 мян. хvн хамрагдаж, шимтгэл толж байгаагийн 234.9 мян.хvн буюу 59.1 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын, 162.6 мян.хvн буюу 40.9 хувь нь тосовт байгууллагын даатгуулагчид байна.

Нийгмийн даатгалын сангаас 2010 оны эхний улиралд нийт 83.4 тэрбум тогрогийн тэтгэвэр олгосны 72.9 хувийг ондор насны, 12.8 хувийг хогжлийн бэрхшээлтэй иргэдийн, 7.5 хувийг тэжээгчээ алдсаны, 6.8 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 173.0 мян.хvнд олгож, 11.2 тэрбум тогрог зарцуулсан нь омнох оны мон veийнхээс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 1.1 сая.хvн буюу 86.1 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 22.7 тэрбум тогрог буюу 67.0 хувиар тус тус буурчээ. Хvний хогжил сангаас иргэн бvрт 70.0 мянган тогрогийг энэ оны эхний улиралд олгож эхэлсэн богоод эхний ээлжинд 1.1 сая иргэнд 78.8 тэрбум тогрог олгогджээ.

Халдварт овчноор 2010 оны эхний улиралд 7.7 мянган хvн овчилж, омнох оны мон veийнхээс 1349 хvн буюу 14.9 хувиар буурсны дотор салхин цэцгээр овчлогчдийн тоо 489 хvн буюу 68.7 хувь, вируст хепатитаар овчлогчдийн тоо 579 хvн буюу 30.4 хувь, тэмбvвгээр овчлогчдийн тоо 244 хvн буюу 20.7 хувь, трихомониазаар овчлогчдийн тоо 210 хvн буюу 16.4 хувь, гонококкт халдвараар овчлогчдийн тоо 169 хvн буюу 11.0 хувь, цусан суулгаар овчлогчдийн тоо 48 хvн буюу 10.3 хувиар тус тус буурч, харин сvрьеэгээр овчлогчдийн тоо 82 хvн буюу 8.0 хувиар оссон байна.

Манай улсад 2010 оны 3 дугаар сард томуугийн цартахлын А хvрээний (H1N1) вирусын халдварын 1 тохиолдол Улаанбаатар хотод бvртгэгдлээ. 2010 оны эхний улирлын байдлаар ХДХВ/ДОХ-ын 4 тохиолдол шинээр бvртгэгдэж, улсын хэмжээнд нийт ХДХВ/ДОХ-ын 66 тохиолдол бvртгэгдсэн байна. Улсын хэмжээнд 2010 оны эхний улирлын байдлаар 4671 гэмт хэрэг бvртгэгдсэн нь омнох оны мон veийнхээс 451 хэргээр буюу 8.8 хувиар буурчээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо омнох оныхоос буурахад омчлох эрхийн эсрэг гэмт хэрэг, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг зэрэг гэмт хэргүүд 25.1-43.5 хувиар буурсан нь голлон нолоолжээ.

## **II. Макро эдийн засгийн үзүүлэлт**

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2010 оны 3 дугаар сард омнох сарынхтай харьцуулахад 2.0 хувь, омнох оны жилийн эцсийнхээс 7.4 хувь, омнох оны мон үеийнхээс 8.5 хувиар тус тус ослоо. Тээврийн болон боловсролын үйлчилгээний бүлгээс бусад бүлгийн үнэ дүнгээрээ 0.2-15.8 хувь нэмэгдсэн нь хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын дүнгээр омнох оны жилийн эцсийнхээс 7.4 хувь осоход нолоолжээ.

Монголбанкны мэдээгээр монгоний нийлүүлэлт (M2) 2010 оны 3 дугаар сарын эцэст 2974.5 тэрбум тог-т хврч, омнох сарынхаас 7.4 тэрбум тог. буюу 0.2 хувиар буурч, омнох оны мон үеийнхээс 621.9 тэрбум тог. буюу 26.4 хувиар осчээ. Гүйлгээнд байгаа бэлэн монго 2010 оны 3 дугаар сарын эцэст 384.5 тэрбум тогрогт хврч, омнох сарынхаас 32.1 тэрбум тог. буюу 9.1 хувь, омнох оны мон үеийнхээс 46.2 тэрбум тог. буюу 13.7 хувиар осчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн орийн үлдэгдэл 2010 оны 3 дугаар сарын эцэст 2721.8 тэрбум тог-т хврч, омнох сарынхаас 6.0 тэрбум тог. буюу 0.2 хувь, омнох оны мон үеийнхээс 50.0 тэрбум тог. буюу 1.9 хувиар осчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн орийн үлдэгдэл 2010 оны 3 дугаар сарын эцэст 149.4 тэрбум тог-т хврч, омнох сарынхаас 2.1 тэрбум тог. буюу 1.4 хувь, омнох оны мон үеийнхээс 17.2 тэрбум тог. буюу 13.0 хувь осчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2010 оны 3 дугаар сарын эцэст 416.5 тэрбум тог. болж, омнох сарынхаас 28.2 тэрбум тог. буюу 6.3 хувиар буурч, омнох оны мон үеийнхээс 150.8 тэрбум тог. буюу 1.6 дахин нэмэгдсэн байна. Үнэт цаасны арилжаа 2010 оны 3 дугаар сард 22 удаа явагдаж, 3.6 тэрбум тогрогийн гүйлгээ хийж, 11.7 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Арилжигдсан үнэт цаасны тоо омнох сарынхаас 7.8 сая ш буюу 3.0 дахин, омнох оны мон үеийнхээс 11.0 сая ш буюу 16.4 дахин осчээ.

Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн нийт хэмжээ 2010 оны эхний улиралд 554.8 тэрбум тог., нийт зарлага, эргэж тологдох цэвэр зээлийн хэмжээ 664.0 тэрбум тог. болж, нийт тэнцэл 109.2 тэрбум тог-ийн алдагдалтай гарлаа. Төсвийн урсгал орлого 539.7 тэрбум тог., урсгал зардал 512.6 тэрбум тог. болж, урсгал тэнцэл 27.1 тэрбум тог-ийн ашигтай гарлаа.

Татварын нийт орлого омнох оны мон үеийнхээс 203.1 тэрбум тог. буюу 73.3 хувиар осоход зарим бүтээгдэхүүний үнийн осолтийн албан татварын орлого 69.6 тэрбум тог. буюу 13.5 дахин, нэмэгдсэн ортгийн албан татварын орлого 41.0 тэрбум тог. буюу 68.6 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварынх 39.8 тэрбум тог. буюу 97.9 хувиар оссон нь голлон нолоолжээ.

Татварын бус орлого омнох оны мон үеийнхээс 3.1 тэрбум тог. буюу 5.6 хувиар осоход төсөвт газрын өөрийн орлого 13.2 тэрбум тог. буюу 73.0 хувь, навигацийн орлого 4.5 тэрбум тог. буюу 2.0 дахин оссон нь голлон нолоолсон байна. Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж тологдох цэвэр зээлийн хэмжээ 2010 оны эхний улиралд 664.0 тэрбум тог. болж омнох оны мон үеийнхээс 223.2 тэрбум тог. буюу 50.6 хувиар осоход татаас, шилжүүлэг 82.6 тэрбум тог. буюу 46.1 хувиар оссон нь голлон нолоолжээ.

Хоронгийн зардалд 2010 оны эхний улиралд 41.4 тэрбум тог. зарцуулсан нь омнох оны мон веийнхтэй харьцуулахад 13.6 тэрбум тог. буюу 49.2 хувиар оссон байна. Хоронгийн зардлын осолтод дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хоронгийн зардал 17.1 тэрбум тог. буюу 72.5 хувиар нэмэгдсэн нь голлон нолоолжээ.

Манай улс 2010 оны эхний улиралд дэлхийн 103 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 1076.2 сая ам.доллар, үүнээс экспорт 499.0 сая ам.доллар, импорт 577.2 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2010 оны эхний улиралд 78.2 сая ам.долларын алдагдалтай гарсан нь омнох оны мон веийнхээс 6.7 сая ам.доллар буюу 9.3 хувиар нэмэгдэв. Нийт бараа эргэлтийн хэмжээ омнох оны мон веийнхээс 360.0 сая ам.доллар буюу 50.3 хувь, үүний дотор экспортын хэмжээ 176.7 сая ам.доллар буюу 54.8 хувь, импортын хэмжээ 183.3 сая ам.доллар буюу 46.6 хувиар осчээ.

Нийт экспортын хэмжээ омнох оны мон веийнхээс осоход цайрын баяжмал үнийн дүнгээрээ 4.9 дахин, томрийн хүдэр үнийн дүнгээрээ 3.0 дахин, жоншны хүдэр, баяжмал үнийн дүнгээрээ 1.9 дахин, нүүрс үнийн дүнгээрээ 5.0 дахин, боловсруулаагүй нефть үнийн дүнгээрээ 5.6 дахин оссон нь голлон нолоолжээ.

### III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

2010 оны эхний улирлын байдлаар 2.7 сая эх мал буюу оны эхэнд тоологдсон нийт эх малын 14.5 хувь нь толлосон байна. Нийт 2130.8 мянган тол бойжиж байгаа нь омнох оны мон веийнхээс 2702.1 мянгаар буюу 2.3 дахин бага байна. Улсын хэмжээгээр 2010 оны эхний улирлын байдлаар 3.8 мянган тэмээ, 207.5 мянган адуу, 347.3 мянган үхэр, 2501.5 мянган хонь, 3250.7 мянган ямаа буюу оны эхэнд тоологдсон нийт малын 14.3 хувьтай тэнцэх 6310.8 мянган том мал зүй бусаар хорогдоод байна. Энэ нь онгорсон оны мон веийнхээс 5.7 сая толгой буюу 10.6 дахин дээгүүр байгаа юм. Нийт хорогдсон малын 51.5 хувийг ямаа эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2010 оны эхний улирлын байдлаар (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 394.2 тэрбум тогтогт хүрч, омнох оны мон веийнхээс 46.4 тэрбум тог буюу 13.4 хувиар ослоо. Энэхүү осолтонд нүүрс, газрын тос, томрийн хүдэр, 47 хувийн агуулгад шилжүүлснээр молибдений баяжмал болон цайр, хайлуур жоншны баяжмал, бvх торлийн малын мах, гурил, архи, дарс, пиво, амтат ус, ундаа, жvүс, тамхи, цемент, шохой, катодын зэс, металл цувимал, ган томор хийц зэрэг аж үйлдвэрийн салбарын голлох нэр торлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл оссон нь нолооллоо.

Омнох оны мон веийнхтэй харьцуулахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт: нүүрс олборлолт (63.6%), газрын тос, шатдаг хий олборлолт (3.3 дахин), бусад ашигт малтмал олборлолт (8.6%), боловсруулах аж үйлдвэрийн салбарт: хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл (59.7%), тамхи үйлдвэрлэл (35.1%), хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт (38.4%), цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт (38.2%), нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх үйл ажиллагаа (30.8%), зэрэг дэд салбарын үйлдвэрлэл нэмэгдлээ.

Улсын хэмжээнд 2010 оны эхний улиралд нийт 8.4 тэрбум тог барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 4.0 тэрбум тог буюу 47.7 хувь нь дотоодын, 4.4 тэрбум тог буюу 52.3 хувь нь гадаадын барилгын байгууллагуудад ногдож байна.

Бvх торлийн тээврээр 2010 оны эхний улиралд 5.0 сая т ачаа, давхардсан тоогоор 61.0 сая зорчигч зорчсон нь омнох оны мон веийнхээс тээсэн ачаа 696.1 мян.тн-оор буюу 16.1

хувь, зорчигчдын тоо 12.7 сая хvн буюу 26.2 хувиар тус тус нэмэгджээ.

Бvх торлийн тээврээр тээсэн ачааны осолтод омнох оны мон veийнхээс авто тээврээр тээсэн ачаа 124.9 мян.тн буюу 10.4 хувиар, томор замын тээврээр тээсэн ачаа 571.1 мян.тн буюу 18.3 хувиар оссон нь нолоолжээ.

Омнох оны мон vetэй харьцуулахад авто тээврээр зорчигчид давхардсан тоогоор 12.6 сая хvнээр, томор замынх 35.6 мянган хvн, агаарын тээврийнх 19.9 мянган хvнээр тус тус осчээ.

Ус, цаг уурын хврээлэнгийн мэдээгээр 2010 оны 3 дугаар сард хамгийн их тунадас (20.9 мм) Баян-Олгий аймгийн Булган суманд орсон байна. Энэ сард агаарын хамгийн их температур Омноговь аймгийн Даланзадгад суманд 21.1 хэм дулаан, хамгийн бага температур Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -46.0 хэм хvйтэн, цасан бvрхvvлийн хамгийн их зузаан Ховд аймгийн Yенч суманд 61 см байлаа.

Салхины хамгийн их хурд Говь-Алтай аймгийн Бугат сум, Омноговь аймгийн Булган суманд 40 м/сек хvрсэн байна. Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2010 оны 3 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 8 удаа, 1-р хороолол орчимд болон 32-ын тойрог орчимд тус бvр 5 удаа, Офицеруудын ордон орчимд 3 удаа, хvхэрлэг хийн агууламж Хан-Уул дvврэг орчимд 24 удаа, Офицеруудын ордон орчимд 23 удаа, 32-ын тойрог орчимд 21 удаа, 13-р хороолол орчимд 20 удаа, 1-р хороолол орчимд 16 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 1-р хороололд 29 удаа, 13-р хороололд 22 удаа тус тус агаарын чанарын стандарт дахь хvлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Онцгой байдлын еронхий газрын мэдээгээр аюулт vзэгдэл, осол 2010 оны эхний улиралд 783 удаа гарчээ. Аюулт vзэгдэл, ослын улмаас 192.0 тэрбум тогрогийн хохирол учирч, 57 хvн амь насаа алдаж, зудны гамшгийн улмаас 5.5 сая мал хорогдсон байна. Аюулт vзэгдэл, ослыг торлоор нь авч vзвэл объектын тvймэр 720 удаа, хvчтэй цасан болон шороон шуурга 11 удаа, газар ходлолт 8 удаа бvртгэгджээ.